



### НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2004 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

#### НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ "УЛААНБААТАР БУЯН" ХХК БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2-ын 4 дүгээр заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2004 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 1/445 албан тоотоор өргөн мэдүүлсэн саналыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Иргэдэд үйлчлэх "Буян компани" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг Нью-Майнд Хязгаарлагдмал хариуцлагатай компанитай нийлүүлэн нийслэлийн өмчийн оролцоотой "Улаанбаатар буян" ХХК-ийг байгуулсугай.

Хоёр. "Улаанбаатар буян" ХХК-ийг байгуулж байгаатай холбогдуулан иргэдэд үйлчлэх "Буян компани" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгаж, уг байгууллагын хаалтын баланс гаргаж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг Өмчийн харилцааны газар / М.Цэрэндорж/-д үүрэг болгосугай.

Гурав. Шинээр өөрчлөн байгуулагдаж буй нийслэлийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид шаардлагатай санхүүгийн дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч / М.Энхболд/-д даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ДАРГА

Т.БИЛЭГТ

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.МАНАЛЖАВ

ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД

П.АЛТАНЦЭЦЭГ  
Т.БАДАМЖУНАЙ  
Д.БААСАНСҮРЭН  
Ц.БААТАРСАЙХАН  
С.НЯМЗАГД  
У.УЛАМБАЯР  
Г.ЭНХТҮВШИН